



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 67,900,000.00 (жаран долоон сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий, хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Алтанбулаг боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашины улсын дугаарыг шилжүүлэн бүртгүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001271

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 04 дүгээр сарын
.....өдрийн 22... тогоолын хавсралт



**Иргэний нисэхийн ерөнхий газраас балансаас Алтанбулаг боомт дахь Хилийн
мэргэжлийн хяналтын албаны балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн
жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиг лалтанд орсон он	Тоо шир хэг	Балансын дүн (төгрөг)	Хуримт лагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэг дэл өртөг (төгрөг)
1	Ланд крузейр 200 маркийн, УНУ 56-13 улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар - JTFSX22P506156324	2015	1	67,900,000.00		67,900,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)	67,900,000.00 (жаран долоон сая есөн зуун мянган)		67,900,000.00 (жаран долоон сая есөн зуун мянган)